

УЛС ТӨР

Н.ГАНХУЯГ: ХҮССЭН,
ХҮСЭЭГҮЙ БИД НҮҮХ Л
ХЭРЭГТЭЙ

II нүүрт

ХҮН

Б.МӨНХЖАРГАЛ: АЖИЛ ХАЙГЧДЫН ИХЭНХ
НЬ ЭМЭГТЭЙЧҮҮД, ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ
ЗАЛУУС БАЙДАГ

VI-VII нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр +17
Шөнө +12

Хэн нь хэн бэ?



УЛААН ТОЙРГИЙН УЛААН “КОММУНИСТ”

Ч.ЧУЛУУН

“Хэн нь хэн бэ” булангийнхаа өмнөх дугаараас УИХ-ын гишүүдийн хэн нь хэн бэ, өмнө нь хэн байв, одоо хэн болов, юу хийж байна, сонгогчдын итгэл найдварыг дааж чадах төрийн түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа мэдээлж эхэлсэн билээ. Өмнөх дугаартаа бид УИХ-ын сонгуулийн 1-10 дугаар тойргийн гишүүдийг онцолж, нэр дэвшигчийн намтар, хувь хүнийхээ хувьд хэн болох, цаашлаад төр түших ажлаа хэрхэн нэр хүндтэй хийж буйг нь уншигчиддаа хүргэсэн. Тэгвэл энэ удаагийн дугаарт, УИХ-ын сонгуулийн 11 дугаар тойрог болох Говь-Алтай аймгаас УИХ-ын гишүүнээр томилогдсон УИХ-ын гишүүн, Хуульзүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэдийг онцлох байна. Харин дараагийн дугаартаа УИХ-ын сонгуулийн 12 дугаар тойрогос сонгогдсон УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг таныг бид онцлох болно.

Үргэлжлэл нь V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ТОХИРОО ХЭРХЭН ҮРГЭЛЖЛЭХ БОЛ...

–Сурталчилгаа эхлээгүй ч сошиал дахь гүтгэлэг,
доромжлол хэдийнэ эхэлчихэж–

Б.ӨНӨРТӨГТӨХ

Ганцхан суудлаар шангаажилж, төрийн ажлыг удтал гацаасан МАХН-ынхан өнгөрөгч мягмар гарагийн орой нэр дэвшигчээр зарлалаа. Намын дарга Н.Энхбаяр ялтайн улмаас өрсөлдөх боломжгүйд хүрч, дараагийн хувилбар хэн байх нь хүлээлт үүсгэж, олон ч таамаг өрнөлөө. Хуулийн хугацаа тулчихсан үед МАХН-ынхан хаалга үүдээ түгжиж орхиод хуралдсан. Бага чуулганы гишүүн хэд байдаг, ямар хүн өрсөлдөж байгаа талаар ч нэгдсэн мэдээлэл байхгүй байлаа. Мягмар гарагийн 21.00 цагийн орчим тэд эцсийн шийдвэрээ гаргаж, намынхаа нэрийг экс гишүүн С.Ганбаатарт “түрээслүүлэх” шийдвэрт хүрснээ зарласан билээ. С.Ганбаатар МАХН-

ын гишүүн биш. Тэрбээр, 2012 оны сонгуулиар Дархан-Уул аймгаас бие даан УИХ-д орж ирсэн ч дундаас нь нам байгуулж, даргаар нь очсон. Гадаадад өндөр боловсрол эзэмшсэн дандаа шижигнэсэн залуусаар эгнээгээ бүрдүүлсэн ХҮН-ын даргаар С.Ганбаатар очсон даруйд асуудал үүсч билээ. Улмаар чадварлаг залуустай нам гэх нэр хүндээ алдаж, олон даргатай болж онигоо болсон түүхтэй. Намын дарга гэх С.Ганбаатар нь боловсрол эзэмшээгүй, намтарт бичсэн олон дээд сургуулийнхаа нэгийг нь ч төгсөөгүй гэсэн баримт олонд ил болсон. Тэгвэл өөрийн гэсэн намгүй, бас баггүй С.Ганбаатарт МАХН ийм боломж олгосон нь хоёр өдрийн ярианы сэдэв байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

Төрийн албаныхан
Си, Ши-гээ ч ялгахгаа
больжээ

Г.ГАНЧИМЭГ

Одоогоос бараг гурван жилийн өмнө буюу 2014 оны намар БНХАУ-ын дарга Си Зиньпин гэргийн хамтаар манай улсад албан ёсны айлчлал хийсэн билээ. Тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар манай улсад хоёр өдөр айлчилсан БНХАУ-ын дарга Си Зиньпиний аюулгүй байдал, хамгаалалт, үйлчилгээний чанарт маш их анхаарал хандуулж байсан. Тэр ч байтугай Ерөнхийлөгчийн хэвлэлийн албанаас бүх л хэвлэл мэдээллийн хэрэгслүүд руу утас цохиж Си Зиньпин даргын нэрийг буруу бичихгүй байхыг хүсч, урьдчилан анхааруулж байлаа. Тусгаар тогтносон бүрэн эрхэт хоёр улсын албан ёсны дээд хэмжээний айлчлал учраас энэ мэтийн нарийн дэг ёс, дипломат харилцаа байх нь зүйн хэрэг. Гэтэл одоо нэг л өөр болчихжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

SKY APARTMENT

ГЕРМАН ЧАНАРЫГ ТАНД МЭДРҮҮЛНЭ

УДАХГҮЙ НЭЭГДЭХ ЗАГВАРЫН БАЙРАНДАА ТАНЫГ УРЬЖ БАЙНА



37мкв, 46мкв, 49мкв, 52мкв,
55мкв, 57мкв талбай бүхий
2 өрөө орон сууцнаас
сонголтоо хийгээрэй



70мкв, 88мкв талбай бүхий
3-4 өрөө орон сууц ердөө
12ш байгаа тул та амжиж
сонголтоо хийгээрэй



Дотроо 2 давхар бүхий
Дуплекс загварын орон сууц нь
112мкв, 104мкв, 125мкв бүхий
3 төрлийн сонголттой



Тансаг зэрэглэлийн Пентхаус загвар нь
4-5 өрөөтэй бөгөөд
88мкв, 90мкв, 129мкв бүхий
3 төрлийн сонголттой

ТӨЛБӨРИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ УРЬДЧИЛГАА 10%

Банкуудаар тусгайлан үйлчлүүлж,
зээлээ **7 хоногийн** дотор
шуурхай шийдүүлэх боломж

ЗГ-аас хэрэгжүүлж буй
Ипотекийн **8%** зээлэнд
хамрагдах боломж

Борлуулалтын компанитай
1-2 ЖИЛ хүртэлх хугацааны
хүүгүй график тохирох боломж



ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

ОРОН СУУЦНААС СОНГОЛТОО ХИЙСЭН ЭРХЭМ ТАНД БИД ДООРХ
ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫГ ҮЗҮҮЛЭХ БОЛНО

Үүдний өрөөний **ХУВЦАСНЫ
ШҮҮГЭЭГ** бэлэглэнэ.

Урьдчилгаа төлбөрөөс хамааран **ҮНИЙН
ХӨНГӨЛӨЛТИЙГ** эдлэнэ.

Sky Апартаментын хаяг: БГД 18-р хороо, Амарсанаагийн гудамж, хуучнаар Од кино театрын баруун талд

facebook.com/TheSkyApartment

УТАС: 88002312, 88030203

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд “УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ” ХХК өөрийн байранд

www.skyapartment.mn

УТАС: 96066329, 77009919

ХААН Банк

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2416.00	2426.00
ЕВРО	2652.00	2715.00
ИЕН	21.37	21.64

	Авах	Зарах
ФУНТ	3084.00	3172.00
РУБЛЬ	41.80	43.80
ЮАНЬ	350.00	353.10

Хугалгаа хөгжлийн банк


	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2416.00	2430.00
ЕВРО	2659.00	2725.00
ИЕН	21.28	21.85

	Авах	Зарах
ФУНТ	3090.00	3164.00
РУБЛЬ	41.66	44.77
ЮАНЬ	350.00	353.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭРГЭЖИЛТНИЙ ҮГ



...Энэ уламжлал бүдгэрч буй нь олон шалтгаантай. Үнэхээр хүн хүчгүй байж болно. Гэхдээ орчин үеийн малчид маань нэг их түвэгтэй зүйл хийгээд байхыг хүсэхгүй болчихжээ. Байшин бариад суурин сууж, хүүхдүүдээ сургуульд өгөхийг боддог болсон байна. Энэ мэтийн олон шалтгаан бий. Гэхдээ манай энэ бүс нутаг их хуурай, хур тунадас бага ордог...

Н.Ганхуяг:

ХҮССЭН, ХҮСЭЭГҮЙ БИД НҮҮХ Л ХЭРЭГТЭЙ

Г.ГАНЧИМЭГ

“Ногоон алт” буюу бэлчээр нутгаа хэрхэн зүй зохистой ашиглаж, талхлагдаж доройтсон бэлчээрийг яаж нөхөн сэргээх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Н.Ганхуягтай цөөн хором ярилцлаа.

–Манай улсын нийт бэлчээр нутгийн 65 хувь нь талхлагдсан гэдэг судалгаагаар та бүхэн гаргажээ. Гэхдээ үүний 95 хувийг 1-10 жилийн хугацаанд дахин сэргээж болно гэж үзсэн юм байна. Энэ талаар тодруулаач?

–Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо нь бэлчээрийн менежментийн чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг мэргэжлийн байгууллага. Тиймээс судалгаа, шинжил-

гэний ажлуудад тодорхой хэмжээгээр оролцдог. 2015 онд үүнийг тайланд болгож гаргасан. УЦЮОШХ энэ тайланд голлох үүрэгтэй оролцсон. Энэ тайлангаар ирэх онд шинэчлэн гаргах юм билээ. Манай байгууллагын хувьд бэлчээр нэгэнт доройтжээ, энэ байдал цаашид үргэлжлэх нь тодорхой болсон учраас малчдыг зохион байгуулалтад оруулж, тулгамдсан асуудлаа харилцан ярилцаж, шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа. Тухайлбал, хөдөө, орон нутаг, суманд юу хийж байна вэ гэвэл дундын бэлчээрээ хамтран ашигладаг нэг нутаг усны малчид хамтраад бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлгийг байгуулахад нь дэмжиж байна. Энэ хэсэг бүлэгт нутаг бэлчээр нэгтэй 30-40 малчин өрх хамтардаг. Ингээд ажилласны үндсэн дээр бэлчээрийн доройтлыг бууруулж, малын чанараа сайжруулах, ашиг орлогоо хүртэл нэмэгдүүлэх гээд тодорхой хэмжээний үр дүн гарч ирдэг. Энэ чиглэлээр баруун бүсийн долоон аймаг сүүлийн 10-аад жил ажиллаж тодорхой хэмжээний үр дүн гарч, маш их хэмжээний туршлага хуримтлуулсан байна. Эдгээр малчдын бүлэг хөгжиж сум, орон нутгийнхаа амьдралд тодорхой хэмжээний байр суурь эзэлдэг болжээ. Тиймээс бид энэ жилээс эхлээд баруун бүсэд хуримтлагдсан туршлагыг төвийн болон зүүн бүс нутагт түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж байна. Саяхан орон нутагт ажиллаад ирлээ. Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгийн малчид бэлчээр доройтож байгаа гэдгийг бүгд мэдэж байна. Эндээс харин хэрхэн гарах вэ гэдэг аргаа олохгүй байна. Ингээд туршлага яриад өгөхөөр тэр хүмүүс “Нээрээ, ингэж нүүх ёстой байсан юм байна”, “Бэлчээрээ заавал сэлтэх ёстой юм байна”, “Дундаасаа мөнгө гаргаж худгаа засах ёстой юм байна шүү дээ” гэдгийг ойлгож эхэлж байгаа юм.

–Сүүлийн жилүүдэд “Ногоон алт”, “Цагаан алт”, “Хар алт” гээд янз бүрийн алтны тухай их ярьдаг болжээ. “Ногоон алт” гэхээр мэдээж тогтвортой

хөгжлийн бодлогыг дэмжиж, ногоон бизнесийг хөгжүүлэх талаар бодлого чиглэгдэх нь ойлгомжтой. Гэхдээ малчны хотонд буюу жинхэнэ бэлчээр ашиглаад явж байгаа хүмүүстээ энэ ойлголт ямар байдаг бол. Өөрөөр хэлбэл, энд тэнд хэрэгжиж буй олон төсөл хөтөлбөр Монголын хөрсөнд яаж бууж байна вэ?

–Монголын хөрсөнд буулгахын тулд аймгийн Засаг даргаасаа эхлээд тухайн орон нутаг, сумынхан, малчид хүртэл энэ чиглэлээр ажиллах хэрэгтэй. Гэхдээ төсөл хөтөлбөр цөөхөн газар хэрэгждэг. Саяхан бидний яваад ирсэн гурван аймагт гэхэд нэг аймгийн 2-3 суманд л төсөл хөтөлбөр хэрэгжиж байсан. Бусад суманд нь иймэрхүү зүйлийг ярихгүй байна. Бид 15 суманд очиж ажиллаад ирлээ. Энэ нь нэг талаасаа малчдаас өөрсдөөс нь их шалтгаалж байгаа. Бидний ярьж буй зүйл бол нэгэнт үр дүн нь гарчихсан туршлага учраас хөрсөнд дээр буулгахад түвэггүй юм. Гэхдээ орон нутгийн малчид маань үүнийг газар дээр нь очиж үзэж гэдэг саналтай байна. Манай нутагт таарч тохирох нүүдэл суудлын арга технологи байвал бид авч хэрэглэж гэж байгаа юм. Тиймээс бид одоо төсөл гэж ярихаас илүүтэйгээр нэгэнт бий болсон туршлагыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажиллаж буй нь арай ололттой.

–Монголчуудын уг гарвал улирлын турш, зарим улирал бүр илүү олон удаа нүүдэг байсан. Гэтэл энэ уламжлал маань алдагдаж, тэр ч байтугай жилийн дөрвөн улирлын турш нэг нутаг дээрээ амьдардаг айл ч бий болсон гэх юм. Энэ нь юугай холбоотой вэ?

–Уламжлалт арга ажиллагаа маань бүдгэрч байна. Яагаад нүүж суудаг байсан, отор нүүдэл хийдэг байсан, эр, сувай малаа оторт гаргадаг байсан зан заншил маань орхигдоод байна вэ гэвэл хамгийн түрүүнд байгаль, цаг уур нөлөөлж байна. Усан хангамжийн хүрэлцэнээс шалтгаалж буй юм. Нөгөөтэйгүүр, төв суурин газар, зам харилцаа, зах зээлээ

бараадсан төвлөрөл бас байлаа. Бидний хийсэн судалгаагаар төвийн бүс нутагтаа нүүдэл суудлын тоо ерөөсөө л дулааны, хүйтний гээд хоёрхон болжээ. Харин баруун бүс нутагт малчид жилд 4-7 удаа нүүдэг уламжлал бас харьцангуй хадгалалдаж үлдсэн байна.

Энэ уламжлал бүдгэрч буй нь олон шалтгаантай. Үнэхээр хүн хүчгүй байж болно. Гэхдээ орчин үеийн малчид маань нэг их түвэгтэй зүйл хийгээд байхыг хүсэхгүй болчихжээ. Байшин бариад суурин сууж, хүүхдүүдээ сургуульд өгөхийг боддог болсон байна. Энэ мэтийн олон шалтгаан бий. Гэхдээ манай энэ бүс нутаг их хуурай, хур тунадас бага ордог. Тиймээс нэг газраа удаан сууж бэлчээр ашиглах боломжгүй бүс нутаг байхгүй юу. Хүссэн, хүсээгүй бид нүүх л хэрэгтэй. Дор хаяж жилдээ дөрөв нүүгээд, цаашилбал, улиралдаа 1-2 удаа холхно нүүдлүүдийг хийж байх ёстой. Малчид үүнийг ойлгож байна. Гэхдээ ахмад малчид илүү түлхүү ойлгодог. Залуу малчид харьцангуй бага ойлгож байна. Тийм учраас энэ чиглэлийн сургалт, мэдээллийг залуу малчид руу илүү чиглүүлэх хэрэгтэй болжээ.

–Нэг ёсондоо залуу малчдад “номын дуу” сонсох хэрэгтэй болжээ гэсэн үг үү. Уг нь амьдрал ахуй, уламжлалаасаа суралцсан байх ёстой зүйл биз дээ. Тэгээд ч нүүдэл суудал хийх нь монгол малчинд шинэ зүйл биш л байлтай?

–Уламжлалаасаа суралцдаг байсан бол одоо тэр уламжлал нь алдагдчихсан. Хамгийн гол нь хүмүүсийн хоорондын харилцаа их холдсон байна. Уулынхаа мухрыг сахиад “Би л хувина борлуулж байвал болно оо” гэсэн сэтгэхүй давамгайлж байна. Ийм учраас ахмад малчин Дорж, Балдан гуянд очиж, мэдэхгүй, чадахгүй зүйлээ асуух нь сул болжээ. Тэгээд ч зах зээлийн нийгэмд шууд айлд давхиад очиход хэцүү болсон цаг юм байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн хүмүүсийн амьдралын хэв маяг, сэтгэхүйтэй холбоотой зүйл маш их байна.



Г.ЧИМЭГ

БОАЖЯ-наас хэвлэлийн бага хурал хийж, Монгол орны байгаль орчны сүүлийн 30 жилийн төлөв байдлын өөрчлөлтөд хийсэн судалгаагаа танилцуулла. Мөн байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайланг танилцуулсан юм.

Хэвлэлийн хуралд холбогдох яам, алба, газар хэлтсийн дарга нар оролцсон бөгөөд БОАЖ-ын сайд Д.Оюунхорол “Манай яамныхан эрдэмтэн судлаачидтай хамтраад сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол орны байгаль орчны төлөв байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ гэдэг судалгааг хийж, тайланг гаргалаа. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, хүний зохисгүй хэрэглээ, үйлдвэржилт нэмэгдэхийн хэрээр хүрээлэн буй орчин бохирдон доройтож, байгалийн

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Сэргээгдэх эрчим хүчний сүлжээ байгуулах хүсэлт илэрхийлэв

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат өчигдөр ОХУ-ын “Россети” компанийн ерөнхий захирал Бударгин Олег Михайлович тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. “Россети” компани сэргээгдэх эрчим хүчний сүлжээ байгуулах төсөл хэрэгжүүлэх саналтай байгаагаа уулзалтын үеэр илэрхийллээ. Монгол, ОХУ-ыг холбосон 500 вольтын хүчин чадал бүхий сэргээгдэх эрчим хүчний шугам сүлжээтэй болох чиглэлээр хоёр ажлыг нь эхлүүлэх хүсэлтийг Ерөнхий сайд дэмжлээ. Шугам

сүлжээтэй болсноор манай улс тогтвортой эрчим хүчээр хангагдах боломж бүрдэнэ. Мөн энэ төслийг хэрэгжүүлснээр цаашид 220 вольтын хүчин чадал бүхий сүлжээгээр өргөтгөхийг талууд зорьж байна. Шилэн кабелиар тавих эрчим хүчний энэ сүлжээний хүрээнд харилцаа холбоогүй Европын улс орнууд нэгдсэн эрчим хүчний тогтолцоотой болохыг зорьж байгаа өнөө үед Монгол Улс үүнд нэгдэж энэ зах зээлд дээр тоглох боломжтойг Ерөнхий сайд тэмдэглэлээ.

Төрийн алба улстөрчдийн гарын шүүс болж байна гэв

УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын гишүүдээс санаачилсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Төрийн албаны зөвлөл /ГАЗ/, Хуульчдын холбооны төлөөлөл, УИХ дахь Ардчилсан намын, МАН-ын бүлгийн гишүүд болон бусад албаныхан оролцов. Хэлэлцүүлгийг нээж УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүн Я.Санжмятаг үг хэллээ. Тэрбээр “Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаагийн хувьд тус хуулийн төслүүдэд анхаарал хандуулж ажиллаж байна” гэлээ. Хэлэлцүүлгийн үеэр олон ч туршлагатай хуульчид байр сууриа илэрхийлж байсан юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн асан М.Батчимэг “Үндэсний аюулгүй байдлын хамгийн том асуудал бол төрийн доройтол буюу төрийн албаны чанарын асуудал болоод байгаа. Төрийн алба улстөрчдийн талбар болоод хувирчигдсан. Муухайгаар хэлбэл гэдний гарын шүүс болоод дуусч байна. Энэ нь төрийн албаны өөрийнх нь алдаа гэхээсээ илүү улстөрчидтэй шууд холбоотой. Төрийн албаны тухай хууль хэлэлцэж байгаатай холбоотой олон хэлэлцүүлэг болно гэж байна. Тиймээс төрийн алба гэх чухал зүйлийг хэлэлцэж байгаа учир томоохон хэмжээний энэ мэт олон хэлэлцүүлэг өрнүүлээсэй гэж хүсч байна” гэв.

А.Цогцэцэг: Хүүхдээ нэмэлтээр угжсан ээжийг торгохгүй

Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуультай холбоотойгоор хүүхдээ хөхөөр хооллоогүй ээжид хуулийн хариуцахаг хүлээлгэн, эхийн сүү орлуулагчийг зөвхөн эмчийн жороор, эмийн сангаар худалдаална гэх мэдээлэл олон нийтийн сүлжээнд тархаж, олон нийтийг багагүй бухимдуулсан. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг өчигдөр мэдээлэл хийлээ. Тэрбээр мэдээллийнхээ эхэнд 2005 онд Эхийн сүү орлуулагчийн тухай хуулийг баталсан. Энэ хууль өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, нэр нь хүртэл хөхний сүүт орлох боломжтой мэт ойлголт төрүүлж байсан учраас шинэчлэх шаардлагатай болсон гэдгээ тайлбарласан юм. Тэрбээр, “Манай улс дэлхий нийтэд эхийн сүүгээр хүүхдээ хооллодог жишиг улсын нэгээр яригддаг байлаа. 90 гаруй хувьтай байсан. Гэтэл энэ тоо 47 хувь болж буурлаа. Дэлхийн улс орнууд 40 хувинаас дээш эхчүүд хүүхдээ нэмэлт сүүгээр угжиж байвал аюултай

төвшин гэж үздэг. Бүсгүйчүүд гоо сайхнаа хадгалж үлдэх, сайхан харагдахын тулд хүүхдээ нэмэлтээр угжиж байна. 0-6 сартай хүүхдэд эхийн сүүнээс өөр юу ч өгөхгүй ба хөхний сүүгээр хооллоогүй эхийг Зөрчлийн тухай хуулиар шийтгэнэ гэсэн ташаа мэдээлэл гарсан. Тийм зүйл байхгүй. Зөрчлийн тухай хуулийн заалтууд нь эрүүл мэндийн ажилтан болон хүнсний бүтээгдэхүүн импортлогч, худалдаалагчдад хамааралтай. Сүүн тэжээлийн эмчийн жороор зөвхөн эмийн сангаар худалдаална гэсэн нь ч ташаа мэдээлэл. Хүнсний тухай хуулиар худалдааны зөвшөөрөлтэй аль ч газар худалдаалах боломжтой. Хилээр хяналтгүй оруулж буй нэмэлт тэжээл нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, стандартын шаардлага хангаагүйн дээр хувцасны лангуу, барилгын материалын дэлгүүр гээд шаардлага хангахгүй газраар худалдаалж байгаа нь тогтоогдсон” хэмээлээ.

Хуульзүйн салбарынхан нээлттэй өдөрлөг хийж байна

Хууль зүй, дотоод хэргийн салбарын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг өчигдөр, өнөөдөр хоёр өдөр Сүхбаатарын талбайд болж байна. Энэхүү “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 11 харьяа, агентлаг, байгууллага нийтдээ 50 гаруй төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаа юм. Өдөрлөгийг нээж Хуульзүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт үг хэлэв. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас өнөөдөр зохион байгуулах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр иргэдэд архивын лавлагаа тодорхойлолт, хуульбарыг шуурхай олгох, суллагдсан хүмүүжигчдийн тодорхойлолт гаргаж өгөх, жирийн дэглэмтэй хорих ангид ял эзлэж буй хүмүүжигчдийн ар гэрийнхнийг нь утсаар яриулах, өргөдөл, гомдол хүлээж авах, үр төлбөртэй эсэх лавлагааг үнэ төлбөргүй олгох зэрэг үйлчилгээ үзүүлэхээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

байгууллагад ажилд орох болон сургалтын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх аж. Мөн хүмүүжигчийн гар урлалын бүтээлийг танилцуулж, худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах юм байна. Тэгвэл өчигдөр Замын цагдаа болон ХЕГ-ын нээлттэй өдөрлөг болсон бөгөөд Хил хамгаалах ерөнхий газрын хувьд хилийн зурвас бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгохоос гадна архивын бүх төрлийн үйлчилгээ, өргөдөл гомдол, байгууллагын хүний нөөц болон боомтын талаар мэдээлэл, зөвлөгөө өглөө. Мөн гэрээт илчлэлийн талаар тодорхой ойлголт өгч хугацаат цэргийн алба хаагчидтай утсаар яриулах, хил нэвтрэсэн лавлагаа олгох зэрэг үйлчилгээ явууллаа. Цагдаагийн Ерөнхий Газрын нээлттэй хаалганы өдөрлөг өнөөдөр болох бол өчигдөр Замын цагдаагийн газраас иргэдийн жолооны үнэмлэхийг хэвлэж өгөх, жолооны үнэмлэх авах бүртгэлийг хийсэн юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

ТОХИРОО

ХЭРХЭН ҮРГЭЛЖЛЭХ БОЛ...

–Сурталчилгаа эхлээгүй ч сошиал дахь гүтгэлэг, доромжлол хэдийнэ эхэлчихэж–

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Нэр дэвшигчдээ 10 тэрбумын босго тавьсан МАХН-ын шалгуурыг хангаж гарч ирсэн С.Ганбаатар хаанаас мөнгө босгосон нь ирэх өдрүүдийн ярианы сэдэв байх биз ээ. Тэрбээр, мягмар гарагийн 24.00 цагаас өмнө эмчийн үзлэгт орж, СЕХ-ноос шаардсан бичиг баримтыг цаг гаруйн хугацаанд бүрдүүлж өгсөн учраас эртнээс найруулсан жүжиг байжээ гэж хардах шалтгаан болж байна. АТГ, цагдаа, шүүх, прокуророос нэр дэвшигчийн тухай мэдээлэл авах, цаашид банк санхүүгийн байгууллагад өр төлбөртэй эсэх гэх мэтээр нийт 17 хуудас бичиг баримтыг СЕХ-д МАН, АН-ын нэр дэвшигчид бүрдүүлж өгсөн. С.Ганбаатар ч адилхан тэр хэмжээний материал цуглуулж өгнө. Гэтэл ажлын цаг дууссан хойно нэгхэн цагийн хугацаанд бүх бичиг баримтыг хураалттай өгсөн нь сонирхолтой байгаа юм. Энэ өнцгөөс харвал С.Ганбаатарыг өрсөлдүүлэх тохироо аль эрт хийгдсэн нь тодорхой байлаа. Гэвч МАХН-ын дарга Бага чуулган, дөрвөн нэр дэвшигчийн өрсөлдөөн зэргээр өрсөлдөгч намынхандаа шантааж үзүүлж, “жүжиг” тавьчихав уу гэх хардлага байгааг нуугтаад явах. Хэнд ч хардах эрх бий. Цаашид гэдний тохироо хэрхэн үргэлжлэх нь сонирхол татах сэдэв байх нь дамжиггүй. Нөгөөтэйгүүр, С.Ганбаатарыг өрсөлдөх сургаар намдаа ганц суудалд авч ирсэн О.Баасанхүү баахан “бин намаасаа гарахгүй” хэмээн өмнөх байр сууринаасаа ухарсан мэдэгдэл хийснээр маргаан өндөрлөв.

Нэр дэвшигчид бүтэн нэр, бүрэн намтартай үлдэх болов уу

Энэ мэтээр Ерөнхийлөгчийн сонгуулийн тойрсон улс төрийн халуун үйл явдал хэдэн өдрөөр сунжирч өчигдөр арайхийн өндөрлөлөө. Гэхдээ зөвхөн нэр дэвшин, дэвшүүлэхгүйн тухай маргаан. Хуулийн хугацаандаа багтаж СЕХ өчигдөр гурван нэр дэвшигчийг албан ёсоор бүртгэж үнэмлэх олгох болсноо зарлав. Тодруулбал, СЕХ-ноос өчигдөр мэдээлэл хийж үнэмлэхийг нь энэ сарын 27-нд гардуулахаа мэдэгдсэн юм. Мөн нэр дэвшигчдийг саналын хуудсанд УИХ дахь намын суудлынх нь тоогоор эрэмбэлэхээр болжээ. УИХ-д хамгийн олон суудалтай МАН-ын нэр дэвшигч М.Энхболд саналын хуудасны нэгдүгээрт бичигдэх бол, АН-ын нэр дэвшигч Х.Баттулга хоёрдугаарт, хамгийн сүүлд МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар бичигдэхээр болсон байна. СЕХ-нд албан ёсоор бүртгүүлснээр тэд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид болж байгаа юм. Төрийн хамгаалалтад орж, хийх үйлдэл, хэлэх үгээ алхам тутамдаа цэгнэх нь. Өмнө хэлсэнчлэн, СЕХ бүртгэх, бүртгэхгүйн тухай маргаан л өчигдрөөр дууслаа. Харин өнөөдрөөс тэдний хэн нь хэн бэ гэдгийг ард түмэн шүүж эхэлнэ. Нэр дэвшигчдийн ард байгаа сурталчилгааны багууд өрсөлдөгчөөр харлуулах ажилдаа шуурхайлж эхэлжээ. Албан ёсны сурталчилгаа сонгууль болохоос 20 хоногийн өмнө эхлэх ёстой ч сошиал ертөнцөд нийм хууль үйлчилдэггүй. Тэнд хэн ч юу ч бичиж болно. Өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг ардчилсан нийгэм учраас Х.Баттулга, М.Энхболд,



С.Ганбаатар нарын нэр хүндийг өндийх аргагүй болтол гүтгэж, гутаах ажлаа тун сурмаг хийх биз. Цаашид твиттер сүлжээнийхэн байна. Хэдийнэ ил, далд сурталчилгаа хийх мөнгөө авчихаад анаж суугаа нь дамжиггүй. Хэдэн төгрөгөөр халаасаа дүүргэхсэн боловсролтой “гүтгэгчид” жиргэх ажилдаа ч ханцуй шамлан орно. Чин үнэнийг хэлэхэд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болох өдөр бүтэн нэртэй, бүрэн намтартай хүн үлдэх үү гэдгийг хэлж мэдэхгүй нь. Тэд хэнийг ч хэн ч биш болгож чадна. Хэдэн үеийнх нь намтрыг ухаажаргана, өмнөх алдаа, хий гийгэсэн бүхнийг шүүн хэлэлцэнэ. Боловсролтой, боловсролгүйн тухай маргаан дөнгөж эхлэл нь. Аав, ээж, амраг садан руу нь дайралтаа үргэлжлүүлнэ. Үр хүүхдийнх нь зургийг гаргаж тавьчихаад хэрэлдэж, хэлэлцэнэ. Дэгсдүүлж хэлбэл, хаана хэнтэй ууж идэж, хэдэн бүсгүйтэй уулзсаныг нь хүртэл гаргаж тавих нь тодорхой. Хамгийн сонирхолтой энэ бүхнийг хүчээр зогсоох боломж манайд даанч алга. Сонгууль дуустал фэйсбүүк, твиттер хуудсыг хаахгүй л бол сошиал сүлжээнийхэнд хууль үйлчлэхгүй. Харилцаахолбооны зохицуулах хороо, СЕХ хэвлэл мэдээлэлээр нэр дэвшигчийн ил, далд сурталчилгаа яаж байгаа эсэхэд л анхаарал хандуулахаас өөрийг хийж чадахгүй. Сошиал сүлжээг тэд яаж ч чадахгүй. Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн нэгнийг улаан цайм сурталчилгаа хийлээ гэж барьж хорихгүйгээс хойш сошиалын “дайн”-ыг дуугүй харж суухаас өөр аргагүй билээ.

Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулья

Ерөөс нэр дэвшигчийн талаар кампанит гүтгэлэг явуулах ажил ганцхан Ерөнхийлөгчийн сонгуулиар болдог юм биш. Шат шатны сонгуулиар л ийм зүйл болдог. Хэдийгээр хэвлэл мэдээлэлээр албан ёсны эх сурвалжтай, ёсзүйтэй, цензуртэй явуулах сурталчилгааны хоног богинохон байгаа ч сошиал сүлжээ гэх олон нийтийн мэдээллийн сүлжээг хянах боломж гарахгүй байгаа юм. Тиймээс ёсзүйтэй өрсөлдөөнөөс илүү ёсзүйгүй, гүтгэсэн, доромжилсон, нэг нэгнийхээ аав ээжийн удам судар, үр хүүхдийнх нь бүдүүн тарганыг шүүх хэлэлцүүлэг хэтэрхий олон хоног үргэлжилж байгааг хөндөхгүй өнгөрч боломгүй. Зургадугаар сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудлыг дөнгөж тавдугаар сар гараад л ярьж эхэлсэн. Хуульд заасан хугацаа нь тийм учраас

яах ч арга байхгүй. Гэтэл тавдугаар сарын эхээр нэр дэвшигчээ тодруулчихсан улс төрийн намууд өнөөх л бохир, заваан гүтгэлгээ хоёр сарын турш явуулах боломжтой болчихоод байна. Хийхгүй, сэтгэхгүй зүйл ч гэж байхгүй юм, тэдэнд. Эцэст нь албан ёсны сурталчилгаа эхлэхэд ард түмэн хэдийнэ өрсөлдөгчдийн сайн муу, саар мэдээнээс залчихсан байдаг. Ямар ч сайн мэдээг хүргэлээ гээд хэдийнэ сошиал ертөнцөөр явчихсан учраас хүлээж авах чадамжгүй болчихдог. Худал үгийг мянга давтахаар үнэн турш Х.Баттулга луйварчин гээд гүтгэгчээр итгэхээс эрхэм хууль санаачлагчид минь хуулийн төслөө эргэж харахад гэмгүй болжээ. Орчин цагтайгаа хөл нийлүүлэн алхаж, нэр дэвшүүлэх, сурталчилгаа эхлэх хоног хугацаагаа жаахан ойртуулвал яадаг юм бэ. Тавдугаар сарын сүүлийн долоо хоногт нэр дэвшүүлэх,

бүртгэх ажлыг хийж, улмаар албан ёсны сурталчилгаа эхлэх өдөр үнэмлэх гардуулахад бүрүүдэх зүйл байхгүй. Сонгуулийн санал авах хэсэг, ажлын хэсгийг нэр дэвшигч хэн байхаас үл хамаарч хийж болно. Саналын хуудас хэвлэх ажил тийм ч олон хоног авах нь юу л бол. Тиймээс Сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулж, нэр дэвшигчдээ гүтгэлэг, доромжлолоос хамгаалъя. Ард иргэдээ үнэн зөв мэдээлэл авах боломжоор хангая. 20 хоног хангалттай хугацаа. Хэвлэл мэдээллийн орон зай асар өргөн байхад фэйсбүүк, твиттерийн дэмжлэггүй сурталчилгаа хийхэд хангалттай хүрэлцэх хоног. Тэгээд ч цөөхөн хэдэн зуун сая хүн амтай биш гуравхан сая монголчуудад хоёр сарын сурталчилгаа хэтэрхий их байгаа юм. Хуулиа өөрчилж чадахгүй бол сошиал сүлжээгээ хаасан ч яах вэ дээ. Бидний тархи хогиин сав биш. Хэрэгтэй хэрэггүй хов жив, гүтгэлэг доромжлол, бөгс бөөрний хэрүүлгийг хоёр сар сонсч, үзнэ гэдэг арай л хэтэрсэн асуудал биш үү.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам нь “Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн сангийн бүтэц, загвар, Монгол Улсын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцлийг тооцох программ хангамжид тавигдах шаардлагыг боловсруулах”, “Органик хүнсний бүртгэл, хяналт, удирдлагын мэдээллийн сангийн бүтэц, архитектуру, програм хангамж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг тодорхойлох” зорилгоор №СХОХ/17/01/01 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дараах чиглэлийн ажлуудаас бүрдэнэ. Үүнд:

Багц А. “Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн сангийн бүтэц, загвар, Монгол Улсын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцлийг тооцох программ хангамжид тавигдах шаардлагыг боловсруулах” ажлын хүрээнд:

1. Монгол Улсын хүнсний хангамжийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдох боломжийг судлах, мэдээллийн сангийн бүтэц, загварыг тодорхойлох;
2. Хүнсний хангамжийн нэгдсэн мэдээллийн сангийн өгөгдөлд тулгуурлан Монгол Улсын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тэнцлийг цахим хэлбэрээр тооцох боломж, тайлагнах арга хэлбэрийг тодорхойлох, програм хангамжид тавигдах шаардлагыг тодорхойлох;
3. Холбогдох байгууллага (олон улсын болон үндэсний) болон олон нийтэд хүнсний хангамжийн талаарх бодит мэдээллийг хүргэх цахим хуудасны бүтэц, загварыг боловсруулах;

Багц Б. “Органик хүнсний бүртгэл, хяналт, удирдлагын мэдээллийн сангийн бүтэц, архитектуру, програм хангамж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг тодорхойлох” ажлын хүрээнд:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчилал хэмжил зүйн газар, 3 төрлийн баталгаажуулалтын байгууллага, органик үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан Органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдаж буй а/органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үеийг эхлүүлсэн, шилжих чадаагүй, органик хүнсний баталгаажуулах тухай гэрээ байгуулсан, баталгаажсан, гэрчилгээ олгогдсон, тудгалзүүлсэн, баталгаажилгыг хүчингүй болгосон аж ахуйн нэгжийн бүртгэх, тайлагнах б/үндэсний, экспорт, импортын

Төрийн албаныхан Си, Ши-гээ ч ялгахаа больжээ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат гэргий Н.Тунгалагийн хамт өмнөд хөрш БНХАУ-д албан ёсны айлчлал хийлээ. Гэтэл нөгөө чухал ач холбогдол өгөөд байсан нэр маань цөөнгүй хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ши Жинпинь гээд л дурайж байх нь тэр. Си Зиньпин шүү дээ гэхээр “Үгүй ээ, цаанаасаа ингэж өгсөн нэр” гэх юм. Хүний нэрийг редакторлах эрх хэнд ч үгүй болохоор тэгээд ч төрийн албан ёсны айлчлалын мэдээ мэдээллийг ганц нэрэн дээр маргаж суусаар хоцроолтой нь биш. Тэгэс ингэхийгээд учраа ололцсон болоод Ши Жинпинь л гэж бичигдээ. Цаг сэлгээтэй байдаг хэдий ч Монголын төр загасны ой санамжтай байж огт болохгүй. Энэ нь өчүүхэн жижиг асуудал юм шиг мөртлөө Монголын төрийн дипломат ёсны нүүр царай шүү дээ. Цаашидад энд ямар хэмжээний боловсролтой ямар хүмүүс яаж ажиллаж байгааг л харуулна. Улмаар олон улс, тив дэлхийд Монгол Улсын нэр төр ямар байх вэ гэдэгтэй ч холбоотой асуудал юм. Манай Гадаад харилцааны яам, дипломат албаны хүмүүс хоорондоо иймэрхүү байдлаар ямар ч уялдаа холбоогүй ажиллаж байхад юун Монгол төрийн алтан аргамж, хар хайрцагны бодлого ярих вэ л болно шүү дээ. Угаасаа л төрийн байгууллагууд хоорондоо ямар ч уялдаа холбоогүй ажилладаг хэмээн иргэд, олон нийтийн төлөөлөл шүүмжилдэг. Үүнийг нь харинуд өдөр болгон Төрийн ордны өмнө жанжин Д.Сүхбаатарын талбайд “Нээлттэй хаалганы хаалттай өдөрлөг” хийж байна. Ажил үйлчилгээгээ сурталчилж байгаа гэх ч нэг л их нарийж, тээршаасан хүмүүс угтаж байгаа нь нууц биш. Энэ өдөрлөгийн гол зорилго нь бушуухан шиг нээлтээ хийсэн болоод дарга нараараа хэвлэлийнхэнд яриа өгүүлэх байдаг бололтой.

Иймэрхүү байдлаар энд цугласан үндсэн ажил нь дуусна. Төр түшицлэж буй хэн ч наад зах нь харилцааны соёл, цаашид боловсрол мэргэжил, ур чадвараа сайжруулах хэрэгцээ шаардлага нийгэмд, энэ улс оронд чинь байна. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа муугаас дотооддоо маш их хэл ам гарч, маргаан тэмцэл нь ил, далд хэлбэрээр явж л байдаг. Одоо энэ асуудлыг цэгцлэхгүй бол хэрээс хэтэрч Гадаад харилцааны яам, дипломат албанд хүртэл ийм төрлийн идээ бээр бутшиж эхэллээ. Энэ нь яван явсаар тив дэлхий, олон улсад Монголын нэрийг хугалж орхих вий дээ. Уг нь нэр хугарахаар яс хугар гэдэг шийртэй улссан даа, монголчууд. Үгүй ядахдаа төрийн албан ёсны мэдээлэл түгээдэг УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн хэвлэлийн алба нь нэр усны талаар нэг ойлголттой байхсан. Си, Ши хоёроо л ялгахгүй боловсролтой хүмүүс төр засгийн бодлогыг олон нийтэд сурталчлаад сууж байна гэхээр эмгэнэлтэй ч юм шиг. Си Зиньпин даргын нэрнээс гадна гэргийнх нь нэрийг ч манайхан түм буман янзаар бичсэн байх жишээтэй. Пэн, Пөн, Пин, Пен гэх мэтээр гарч ирнэ. Хятад нэр өөрөө ганцхан үсгэнээ л болж угтаа нь тэр чигээрээ өөрчлөгддөг. Гэтэл манайд бол зүгүлүүлж л байвал яаж ч бичсэн хамаагүй болчихоод байгаа юм. Тиймээс Гадаад харилцааны яам энэ талаар жаахан анхаарвал яасан юм бэ. Ядахдаа дипломат харилцаатай улс орнуудын төрийн тэргүүн, Ерөнхий сайд, төр засгийн өндөр албан тушаалтнуудын нэрийг нэгдсэн байдлаар яаж бичихийг гаргачихаж болмоорсон. Үүнийгээ төрийн мэдээлэл түгээдэг хэлтэс албадууддаа албан бичгээр ч болов хүргэхийг тийм ч их мөнгө орохгүй. Зөвхөн сэтгэл л дутаж байгаа хэрэг. Өөрийн цахим хуудсанд ааруулчихсан байхад хэвлэл мэдээлэл хэрэг болгож ороод авчихаж дөнгөлгүй яахав. Энэ мэт жижиг юм шиг боловч, улсын минь нэр хүнд, цаашид хэвлэлийн бидний нүүрийг улайлгасан асуудал мөн ч олон байна даа.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайгаа нотлож, дараах мэдээлэл, баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуудбар;
- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан;
- Энэхүү зөвлөх үйлчилгээний цар хүрээтэй ижил төрлийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг агуулсан жагсаалт, мөн өмнөх 2-3 худалдан авагчийн тодорхойлолт /сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн/;
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэн ажиллах боловсон хүчний ажлын туршлага болон ур чадварын талаарх мэдээлэл /иргэний үнэмлэх болон мэргэжлийн дипломын нотариатаар баталгаажуулсан хуудбар/;

Ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг ХХААХҮ-ны Хүнсний үйлдвэрийн Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах газрын 502 тоотос авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 17.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын 9 дүгээр байр, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 5 дугаар давхар, 502 тоот өрөө, Утас: 261506 факс: 453121

МЭДЭЭЛЭЛ

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: 133 дугаар цэцэрлэгийн сантехникний бохирын шугамын засвар /Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/-ын ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0141

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос 133 дугаар цэцэрлэгийн сантехникний бохирын шугамын засвар /Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Санал болгож буй үнийн саналын 30 хувиас багагүй байна;

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он;

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийж гүйцэтгэсэн байх;

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- 2.2.2 Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 1 400 000 /Нэг сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн, 15 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: **Оролцох эрхгүй**
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
Холбоо барих утасны дугаар: 75757807
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “СЭЛБЭ, УЛИАСТАЙ, ТҮРГЭНИЙ ГОЛЫН УРСАЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР ГОЛЫН ЭХ, ХӨНДИЙГ ОЙЖУУЛАХ АЖИЛ”
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0132

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эрх бүхий тендерт оролцогчдоос “СЭЛБЭ, УЛИАСТАЙ, ТҮРГЭНИЙ ГОЛЫН УРСАЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР ГОЛЫН ЭХ, ХӨНДИЙГ ОЙЖУУЛАХ АЖИЛ” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 3 жил /2014, 2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:

Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил буюу /2015, 2016 он/

Тусгай зөвшөөрөл шаардлагатай:

Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яамны сайдын 2013 оны А/223-р тушаалаар батлагдсан “Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам”-ын 2.5. дахь заалтад заасан:

2.5 Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх:

Тендерийн баталгааны үнийн дүн: 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 13:00 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 13:30 цагт Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: 124 дүгээр цэцэрлэгийн засвар /ЧД, 10 дугаар хороо/-ын ажил
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0147

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос 124 дүгээр цэцэрлэгийн засвар /ЧД, 10 дугаар хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын дундаж орлого санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна;

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 он;

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2015, 2016 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тусгай зөвшөөрлийн хүрээнд ажил хийж гүйцэтгэсэн байх;

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Барилга, хот байгуулалтын яамны дараах зөвшөөрөлтэй байна. Үүнд:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 900 000 /есөн зуун мянга/ төгрөгийг дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн, 08 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: **Оролцох эрхгүй**
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
Холбоо барих утасны дугаар: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ТЭНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Аялал жуулчлалын авто замын шинэчлэлт 2.05 км /Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо/-ийн ажил”
Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-17/0133

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Аялал жуулчлалын авто замын шинэчлэлт 2.05 км /Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо/-ийн ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж цахим тендерийн баримт бичиг болон холбогдох материалыг татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50 000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:

Төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байна.

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудад доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 3 жил /2014, 2015, 2016 он/-ийн санхүүгийн тайлан ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл:

1. Зам тээврийн яамны:
 - 2.8.1 Хатуу хучилттай зам барих болон эсвэл
 - 3.7.1.1.6 ЗБ-1-6 /3 км хүртэл/ үүнээс дээш
2. Эрчим хүчний яамны:
 - 03.2.1 0.4-10 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт түүний тохируулга, дагалдах ажил үйлчилгээ.
3. Харилцаа холбооны зохицуулах хорооны:
 - Б ангилал 5 Харилцаа холбооны сүлжээ дэд бүтцийн суурилуулалт засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл. Үүнд: Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар

Тендерийн хамт 29,580,000 (хорин есөн сая таван зуун наян мянга) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 13:30 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 14:00 цагт Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж,
Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

ЧУХАЛ ХҮН

Б.МӨНХЖАРГАЛ: АЖИЛ ХАЙГЧДЫН ЭМЭГТЭЙЧҮҮД, ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ

Б.СУМБЯА

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнхжаргалыг "Чухал хүн" буландаа урьж ярилцлаа.

Юуны түрүүнд аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн өнгөрсөн хугацаанд баримталсан бодлого, ажил үйлсээс ярилцлагаа эхлэх үү?

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд олон бүтээлч ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд манай аймагт улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар нийт 176.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ихэнх нь эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын салбарын бүтээн байгуулалт болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг нь нийлүүлэхэд чиглэгдсэн. Үүний үр дүнд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон дэвшил гарч иргэд төрөлх нутагтаа ажилтай, орлоготой, тогтвортой амьдрах нөхцөл боломж бүрдлээ. Ялангуяа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд аймаг орон нутгийн төвшинд анхаарч, тодорхой бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлсний үр дүнд 2013-2016 онд байнгын 6881, түр ажлын байр 3969, нийтдээ 10850 ажлын байр шинээр бий болгосон байна. Ингэхдээ ажилгүй иргэдийг ажилд авсан, шинээр ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжид тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг, урамшууллыг орон нутгийн төсвөөс олгосон. Эцсийн үр дүндээ иргэд баталгаатай ажлын байртай болж, амьжиргаа нь ч дээшилсэн хэрэг. Бас 19 сумын "Бизнес хөгжлийн төв"-ийн халаалтын зардалд орон нутгийн төсвөөс 301.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл боломжоор нь хангаж, үйл ажиллагааг нь тогтмолжуулсан байгаа.

Өрхийн амьжиргааны төвшин тогтоох судалгаанд аймгийн хэмжээнд хэчнээн өрх хамрагдав?

Өрхийн амьжиргааны төвшин тогтоох судалгаанд 22971 өрх хамрагдсан. 20216 өрхийн мэдээллийг программд шивээд байна.

Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн хүртээмж муу байдаг. Танай аймгийн тухайд боловсролын үйлчилгээний хүртээмж хэр байдаг вэ. Энэ онд сургууль, цэцэрлэг шинээр баригдах уу?

Тийм ээ, хэд хэдэн сумын сургууль, дотуур байрыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байгаа. Тодруулбал, Арвайхээр сумын 928 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлж, Есөнзүйл сумын бага сургуулийн барилга, Хужирт сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, энэ ондоо ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Мөн Хужирт, Богд, Төгрөг сумдын дотуур байрны барилгад засвар хийхээр зураг төслийг нь боловсруулсан байгаа. Одоогоор гүйцэтгэлийг сонгон шалгаруулах шатандаа явж байна.

Төгсөх ангийн сурагчид элсэлтийн ерөнхий шалгалтаа өгч, ирээдүйн мэргэжлээ сонгож байна. Өвөрхангай аймагт ЭЕШ өгөх хэчнээн сурагч байна вэ. Тэдэнд мэргэжлээ зөв сонгох талаар зөвлөгөө, мэдээлэл өгч байна уу?

ЭЕШ өгөхөөр нийтдээ 1455 сурагч бүртгүүлсэн байгаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх БСУГ-ын зөвлөн туслах баг ажлын удирдамжаа тусган, сумдаар явж, төгсөх ангийн сурагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Бас Ерөнхий боловсролын сургуулиуд өөрсдөө энэ чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулаад хэвшчихсэн гэж хэлж болно.

Нийгмийн салбарын хөгжлөөр аймгийн хөгжлийг тодорхойлоно гэвэл та санал нийлэх үү. Хэрвээ санал нийлж байвал, танай аймгийн хувьд

энэ хөгжил ямар үзүүлэлттэй байх бол?

"Өвөрхангай аймгийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлын судалгаа"-г өнгөрөгч онд хийсэн юм. Судалгаагаар аймгийн цаашдын хөгжилд эрсдэл учруулах, иргэдийн аж амьдралд сөргөөр нөлөөлөхүйц тулгамдсан асуудлыг эмзэг байдлын үнэлгээний аргачлалаар тодорхойлон гаргасан.

Тэгэхэд, тулгамдсан асуудлуудын тэргүүн эгнээнд уур амьсгалын өөрчлөлт, ядуурал, үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжлийн сул байдал, орчны бохирдол, экосистемийн доройтол бичигдсэн байсан. Ер нь сүүлийн 10 жилд аймгийн төвд амьдрах өрхийн тоо 33.9 хувь, сумын төвд амьдрах өрхийн эзлэх хувь 17.5-аар тус тус өссөн байхад, эсрэгээр хөдөөгийн багт амьдардаг өрхийн эзлэх хувь 21.95 хувиар буурсан байх жишээтэй. Энэ нь байгаль цаг уурын бэрхшээлийн улмаас малгүй өрхийн тоо нэмэгдэж, төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, ядуурал ихсэх хандлагатай болсноос үүдсэн хэрэг.

Дээр нь төв сууринг чиглэсэн шилжилт нэмэгдсэнээр агаарын бохирдол, орчны эрүүл ахуй, хүн амын эрүүл мэндийн асуудалд сөргөөр нөлөөлөх болно.

Ажилгүйдэл, ядуурлыг орон нутгийн төвшинд бууруулах бодлогыг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх нь танай хэлтсийн анхаарах ажлуудын нэг шүү

...Манай аймгийн нийт хүн амын 63.4 хувийг хөдөлмөрийн насныхан эзэлдэг. Тэгэхээр хөдөлмөрийн нөөц байна гэсэн үг. Ажилгүй иргэдийг боловсролын төвшингөөр нь ялгаж үзвэл, 41 хувь нь бүрэн дунд, есөн хувь нь тусгай дунд болон мэргэжлийн, 13.7 хувь нь дээд боловсролтой залуус байдаг. Мэргэжил эзэмшсэн ч, түүнийхээ үр өгөөжийг хүртэж чадалгүй, ажилгүйдэлд өртөх эрсдэл өндөр байна...

дээ. Ажилгүйдэл, ядуурлын төвшин ямар байна вэ. Үүнийг бууруулах чиглэлд ямар арга хэмжээ авч ажиллаж байх юм?

Манай аймгийн нийт хүн амын 63.4 хувийг хөдөлмөрийн насныхан эзэлдэг. Тэгэхээр хөдөлмөрийн нөөц байна гэсэн үг. Ажилгүй иргэдийг боловсролын төвшингөөр нь ялгаж үзвэл, 41 хувь нь бүрэн дунд, есөн хувь нь тусгай дунд болон мэргэжлийн, 13.7 хувь нь дээд боловсролтой залуус байдаг. Мэргэжил эзэмшсэн ч, түүнийхээ үр өгөөжийг хүртэж чадалгүй, ажилгүйдэлд өртөх эрсдэл өндөр байна. Манайх ядуурлын хэд хэдэн хэмжүүрээр улсын дундажаас дөмжүүр үзүүлэлттэй байдаг. Амьжиргааны баталгаажих төвшинөөс доогуур орлоготой иргэд хүн амын 29.3 хувийг эзэлдэг. Цаашлаад ажилгүйдлээс шалтгаалан сэтгэл гутрал, архи тамхины хэрэглээ нэмэгдэж байгаа нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Хэдий аймаг хөгжлийнхөө төвшин, эдийн засгийн өсөлтийн хурдаараа улс хийгээд хангайн бүсэд өндөр үзүүлэлттэй байгаа ч, эдийн засгийн бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлага бий. Тиймээс судалгаа шинжилгээ хийж, 2014-2024 онд эдийн засгийг хөгжүүлэх бодлогын баримт, бичиг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

Хөдөө, орон нутагт ажлын байрны олоцд муу байдаг. Ажил олдохгүйгээс болж залуус нийслэлийг зорих нь бий. Танай аймгийн хувьд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд хэрхэн анхаарч байна вэ?

Хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх чиглэлээр аймаг орон нут-

гийн төвшинд "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажлын байрыг бий болгох дунд хугацааны хөтөлбөр", "Ажил олгогчийг урамшуулах журам", "Залуу малчдыг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байгаа. Манай хэлтэст өнгөрсөн оны байдлаар ажил хайж бүртгүүлсэн иргэдийн 36.0 хувь нь 25-34 насныхан, 23.8 хувь нь 35-44, 17.5 хувь нь 16-24, 22.5 хувь нь 45-аас дээш насныхан байсан.

Иймээс 2016 оныг залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, залуучуудын дунд ажил, амьдралынх нь хэрэгцээ шаардлагыг тодорхойлох хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан санал, санаачлагыг бодлого төлөвлөгөөндөө тусган ажиллаж байгаа. Цаашдаа төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэмүү өртөг шингээсэн кластер хэлбэрийн инновацид суурилсан үйлдвэрүүдийг хөгжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, гадаад зах зээлд түшиглэсэн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх менежмент барьж байна. Өндөр технологи шингэсэн импортыг орлох, экспортод чиглэсэн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүхий эдийг бүтээгдэхүүн болгох, борлуулах зах зээлийг шийдэж өгөхийн тулд гадаад харилцааг хөгжүүлэх гэх мэт ажлыг төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн. Хөдөө орон нутгийн тухайд эдийн засгийн болон менежментийн хувьд

тогтворжсон хоршоо, нөхөрлөл, малчны бүлгийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байна. Ер нь бол ажил хайгчдын ихэнх нь эмэгтэйчүүд, дээд болон мэргэжлийн боловсролтой залуус байдаг.

Халамжийн үйлчилгээ хүртдэг хүмүүс хэр олон байдаг вэ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэдний орлоцдоог нэмэгдүүлэхэд хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?

Давхардсан тоогоор 36.3 мянган хүн халамжийн үйлчилгээ авч байгаа. Бидний хувьд нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хүртээмжийг зөв зохиистой зохицуулах, урьдчилан сэргийлэхэд нийгмийн хамгааллын бодлого чиглүүлж ажилладаг юм. Энэ хүрээнд эмзэг бүлгийнхний нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд эмэгтэйчүүд, архины хамааралтай иргэд зэрэг зорилготой бүлгүүдэд сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулдаг. Бас олон улсын байгууллага хувийн хэвшил, иргэд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллаж байна. Түүнчлэн, 2010 оноос "Тэр бүл хүний хөгжлийн төв", 2012 оноос "Насан туршийн боловсролын төв" зэрэг иргэдэд мэдээлэл, сургалт зөвлөгөө өгөх төвүүдийг нээн ажиллуулах болсон. Иргэдээ хөгжлийн бэрхшээлд өртөхөөс сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд тулгарсан бэрхшээлийг нь хөнгөвчлөх, бусадтай адил



тэгш боломж олгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа. Тухайлбал, аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгааллын хөтөлбөр, харааны бэрхшээлтэй иргэдэд дугаар харгалзахгүй үйлчлэх үнэмлэх олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодод санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг дурьдаж болно.

Танай аймгийн иргэд хэчнээн төрлийн халамжийн үйлчилгээг авч байна вэ. Хөдөө, орон нутагт халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд ямар асуудал тулгардаг бол?

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтөд зайлшгүй хамрагдах шаардлага хангасан иргэдийг 16 төрлийн халамжийн үйлчилгээнд хамруулдаг.

Хөдөө орон нутагт эдгээр иргэдийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр төсөл хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр дутмаг байдгийг нуугаад явах. Зорилготой өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, аймаг орон нутгийн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд зарцуулах санхүүжилт мөн бага байдаг.

Соёл, урлагийн үйлчилгээг ч дэмжиж ажилладаг байх. Хүүхдүүд урлагийн боловсрол олгох, соёл, урлагийн салбарыг хөгжүүлэхэд ямар ажлыг хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөдөөгийн иргэдэд үзүүлэх зайны болон нүүдлийн үйлчилгээг өргөжүүлэн, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах зэрэг

зорилтыг дэвшүүлсэн байгаа. Тухайлбал, эхний ээлжинд соёл урлагийн байгууллагуудыг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, энэ чиглэлд гадаад дотоодын хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага байгаа.

Тарагт, Гучин-Ус, Бат-Өлзий, Өлзийт, Баянгол, Хархорин суманд соёлын төвийн барилга, Арвайхээр суманд Кино театр шинээр барьж, аймгийн Хөгжимт драмын театр, Занабазар музейн барилга, Хужирт, Бүрд, Нарийнтгээл сумын соёлын төвийн барилгад их засвар хийж соёл, урлагийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулахаас гадна хувь хүний бүтээлч, сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгийг хөгжүүлэхүйц соёл, урлагийн шинэлэг ажлыг орон нутагт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, "Соёлын үйлдвэрлэл" аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дээр нь хүүхэд залуучууд, ардын авьяаснуудын авьяас билгийг хөгжүүлэхийн тулд соёл урлагийн нэгдсэн арга хэмжээ, уралдаан, наадам зохион байгуулж, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын драмын театрын тайзнаа тавигдсан сонгодог бүтээлүүдийг орон нутгийн иргэддээ үзүүлж, сонгодог урлагийг сурталчилна.

Боловсон хүчний асуудлыг ч орхигдуулж болохгүй. Энэхүүэнд хөгжим бүжгийн багш бэлтгэдэг их, дээд сургуультай хамтран, орон нутагт элсэлт зохион байгуулах, мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах зэргээр сумдын соёлын төвүүдийн мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр

төлөвлөсөн. Эхнээсээ ажлууд хийгдээд явж байна.

Хүүхэд, залуучууд төдийгүй иргэдийн хувьд бие бялдрын хөгжил маш чухал. Танай аймагт хэчнээн спортын дугуйлан хичээллэж байна. Спортын төрлийг нэмэгдүүлэхэд ямар ажил хийх бол?

Өнөөдрийн байдлаар спортын ордны дэргэд спортын 11 төрлийн дугуйланд 368, сумдын ерөнхий боловсролын сургуулийн дэргэд спортын 12 төрлөөр 6629 тамирчин хичээллэж, аймгийн хэмжээнд 33 чийрэгжүүлэх өрөө, танхим байгуулан 415 хүн тогтмол хичээллэж байгаа. Цаашд бид нийтийн биений тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өргөжүүлж, биений тамир спортыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх төвүүдийг дэмжин, усан бассейн ашиглалтад оруулж, дугуйн замтай болох зорилтыг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Энэ ажлын хүрээнд сум, байгууллага, аж ахуйн нэгжүүд ажиллагсадын хэрэгцээ шаардлагад нийцсэн нийтийн биений тамирын талбай, спорт заал, чийрэгжүүлэх танхим, ногоон байгууламж бүхий гүйлт, алхалтын зам, талбай байгуулах, сэргээн тохижуулах ажлыг өрнүүлэх юм. Мөн Арвайхээр болон зарим сумдад дугуйн зам бүхий цэцэрлэгт хүрээлэн, тамирчдын орон нутагтаа бэлтгэл сургуулилт хийх бэлтгэлийн бааз байгуулах зэрэгцээ жилийн дөрвөн улиралд ажиллах нөхцлөөр хангахад биений тамир, спортын холбоодтой хамтарч ажиллана.

Бокс, таеквандо, сагсан бөмбөг, ширээний теннис, үндэсний

ЧУХАЛ ХҮН

ИХЭНХ НЬ ЗАЛУУС БАЙДАГ

сур зэрэг аймгийн өсвөрийн шигшээ багийг нэмж байгуулан, самбо, жүдо, чөлөөт бөх, шатар, гар бөмбөг, хөл бөмбөг, цана, үндэсний бөх, хөнгөн атлетикийн шигшээ багийг түлхүү хөгжүүлэн багийн болон оюуны спортыг дэмжин, олимпын төрлийг спортын тэргүүлэх чиглэл болгож хөгжүүлэхээр төлөвлөдөг байгаа.

-Эрүүл мэнд эрхэм баян гэдэг. Аймгийн ЭМГ, БОЭТ, сум өрхийн ЭМТ иргэдэд хүртээмжтэй үйлчилж чадаж байна уу. Энэ асуудал бүх аймагт тулгамдсан асуудал болж?

-Эрүүл мэндийн салбарыг 2010-2014 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлсний дүнд эхийн эндэгдлийг өмнөх таван жилийн дунджаас 27.7 хувь бууруулж төлөвлөгөө хэрэгжсэн. Таван жилийн дунджаар 100 мянган амьд төрөлтөд 46.8, нялхсын эндэгдэл буюу 19.2 хувь болж буурсан ч, Мянганы хөгжлийн зорилтыг хангаж чадаагүй цөөн аймгийн тоонд багтсаар л байгааг нуухгүй. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж байгаа. Тодруулжхэлбэл, хүн амын дундах халдварт бус өвчлөл, түүний шалтгаант нас баралт өндөр байгаагас дундаас наслалтын үзүүлэлт улсын дунджаас доогуур байгаа юм. Дээр нь эх, хүүхдийн эндэгдэл буураагүй, улс аймгийн дунджаас өндөр. Бас эмнэлгийн хоног болоогүй нас баралт ихэссэн. Анхан шатны тусламж үйлчилгээний багцад заасны дагуу тусламж үйлчилгээ үзүүлж чадахгүй байгаа. Ялангуяа лабораторийн болон багажийн шинжилгээний чадавхи сул, урвалж, оношлуурын зардал хүрэлцдэггүй. Лавлагаа тусламж, мэргэжил арга зүйгээр хангах үйл ажиллагаа дутмаг байгаагаас гадна зарим нарийн мэргэжлийн эмч нар дутагдалтай байгаа. Энэ мэтээр улсын эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй нийтлэг асуудал манайд ч байна. Иймд бид оношилгоо, эмчилгээнд нэвтэрч байгаа шинэ дэвшилтэт технологийг дагасан шинэ эрэлт, хэрэгцээг хангахуйц, шинэ болон дахин сэргэж байгаа өвчлөл, эндэгдлээс сэргийлэх аргад ард иргэдийг сургахад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэн тэргүүний зорилт болгосон, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг хангахад бүрэн чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр боловсруулсан.

-Эмчилгээ, үйлчилгээний төсөв ер нь хүрэлцдэг үү?

-Эрүүл мэндийн салбарт Сангийн сайдын баталсан төсвийн хуваарийн дагуу л зарцуулж байна. Аймгийн эрүүл мэндийн салбарынхан сүүлийн жилүүдэд аль болох өр авлагагүй ажиллахыг зорьж, түүнийгээ ч биелүүлж ирсэн. Эмчилгээ үйлчилгээг тасралтгүй чанартай явуулахад анхаарч, орон нутгийн төсөв, хөгжлийн сангаас өнгөрсөн дөрвөн жилд нэг төрбүм орчим төгрөгийг зарцуулаа. Өрхийн эрүүл мэндийн стандартад нийцсэн гурван барилга барьж, тоног төхөөрөмжөөр хангалаа. Түүнчлэн, БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмж нийлүүлж, сумдын эмнэлэгт анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, сэргээнзасах, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмжөөр хангасан. Тэр дундаа хамгийн чухал нь мэргэжилтнүүдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад чиглэсэн урамшууллын бодлого хэрэгжүүлсэн байгаа.

-Нийгмийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн ойрын болон хэтийн төлөвлөгөөг тань сонирхмоор байна?

-Улс, аймгийн хөгжлийн социализмын үед таван жилийн төлөвлөгөөгөөр хэмждэг байв. Харин орчин үед 10-20 жил гэх мэт урт хугацаагаар тогтвортой

...Манай аймгийн тухайд эдийн засгийг хөгжүүлэх 2014-2024 оны бодлогын баримт бичиг боловсруулснаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдээ ажилтай орлоготой орон нутагтаа сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөгжлийн стратегийн зорилгоо эрэмбэлсэн байгаа...

хөгжлийн үзэл баримтлалаа олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, түүнийгээ үндсэн дээр хөгжлийн бодлогоо дунд болон урт хугацаагаар төлөвлөх хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн шүү дээ. Манай аймгийн тухайд эдийн засгийг хөгжүүлэх 2014-2024 оны бодлогын баримт бичиг боловсруулснаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдээ ажилтай орлоготой орон нутагтаа сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөгжлийн стратегийн зорилгоо эрэмбэлсэн байгаа. Ингэхдээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилго, зорилтыг гадаад орчны нөхцөл байдалтай нийцүүлэн тодорхойлж, салбар бүрийн бодлогыг өөр хооронд нь уялдуулан аймгийн зах зээлийн багтаамж, нөөц боломжоо тодорхойлсон.

Ирэх жилүүдэд нийгмийн салбарт хүн амын эмзэг хэсгийн зорилтот бүлэгт хандсан, аймгийн ногоон ажл эрхлэлтийг нэмэгдүүлж, зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний сурч боловсрох, эрх зүйн үйлчилгээ авах эрхийг хангах, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн тулд “Нэг өрх-нэг ажлын байр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Аймгийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, ажилгүйдлийг бууруулах” “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх”, “Архидалтгүй-Өвөрхангай”, “Иргэний боловсрол”, “Оюулаг Өвөрхангай”, “Хүүхдэд ээлтэй аймаг” зэрэг 10 гаруй хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

-Та боловсролын салбарт ажиллаж байсан хүн. Ажлын талбарт анх гарч байсан тэр үеийн боловсролын салбар өнөөдөр хэр их өөрчлөгдсөн бэ. Онцлох, ялгарах зүйл юу байна?

-Би 1980-аад оноос эхэлж боловсролын салбарт ажилласан. Тэр үед манай улсын боловсролын систем тогтолцоо хуучин ЗХУ-ынхтай адил их академик шинжтэй, агуулга багтаамж сайтай байсан. Багш нарын заах арга ур чадвар их сайн. Хүүхэдтэй их ойр дотно ажилладаг, сургалтын үнэлгээ багш нарын дүн хатуу чанга байлаа. Сургалтын орчин тухайн үедээ л

их сайн бүрдсэн, ялангуяа хичээл дээр сорил дадлагын ажлыг сайн хийдэг байжээ. Одоо үеийнхтэй харьцуулбал, бүрэн дунд боловсролын сургуулийн тоо их цөөн байсан. Ер нь 1980-аад онтой харьцуулахад боловсролын салбар маш их өөрчлөгдсөн, бас хөгжсөн байна. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын боловсролын салбарын олон сайн туршлагауд, дэвшилтэт арга технологиуд ихээр орж иржээ. Орчин үеийн багш нар сургалтынхаа агуулга, арга зүй, үнэлгээндээ олон шинэчлэлт хийж, өөрчлөгдөж байна. Энэ хугацаанд боловсролын систем хэд хэдэн удаа шинэчлэгдсэн байдаг. Нэг үгээр хэлбэл, боловсролын салбарт хүний хөгжилд түлхэц болсон сайн зүйл ч байна, бас шүүмжлэлтэй зүйл ч байна.

-БСШУСЯ-наас хүүхэд бүрийг авьяасыг нээх, багш бүрийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байгаа. Үүнд та ямар бодолтой явдаг вэ?

-БСШУСЯ-аас хүүхэд бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх, багш бүрийн хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд Өвөрхангай аймгийн жишээн дээр ярихад, багаас нь хүүхэд бүрийн авьяасыг нээж хөгжүүлэхэд ахиц дөвшил гардаг. Энэ чиглэлээр сургууль боловсролын байгууллагын удирдлагууд, багш нар ч сайн ажилласан.

Манай аймагт хүүхдийн авьяасыг хөгжүүлэх чиглэлээр 50 гаруй төрлийн дугуйлан хичээллэж, ЕБС-ийн багш нараас гадна тухайн чиглэлийн ардын авьяастнууд, мастерууд олноор ажилласан нь үр дүнгээ өгсөн гэж олзуурхаж байгаа. Манай аймгийн багш нарын 56 хувь нь Монгол Улсын зөвлөх, тэргүүлэх, заах аргач зэрэг цолтой болж, ур чадвар нь илт сайжирсан гээд маш их зүйлийг ярьж болно. Үүний үр дүнд сургалтын чанар элсэлтийн ерөнхий шалгалтаар 527.6 оноонд хүрч, улсын дунджаас 20 гаруй оноогоор илүү гарч, улсын хэмжээнд тэргүүлжээ.

-Бага ангийн багш тухайн хүүхдийн суралцах арга барил эзэмших үндсийг нь тавьдаг. Тэгэхээр бага ангийн багш нар ямар зарчмаар ажиллавал хүүхэд бүрт ээлтэй байж чадах вэ?

-Бага ангийн багш тухайн хүүхдийн суралцах арга барил, хөгжил төлөвшилийн үндсийг тавьдаг. Үүгээрээ үүрэг харууцлага онцгой их. Тиймээс бага ангийн багш нар ямагт өөрийнхөө хөгжүүлж, мэдлэг боловсрол ур чадвараа байнга дэвшлүүлэн, хүүхдийн хөгжлийн зөв сайн толь байх учиртай. Тэдний хамгийн гол баримтлах зарчим нь хүүхдүүдтэйгээ цаг ямагт зөв сайн харьцах явдал гэж би боддог.

-Төр засгаас таны хөдөлмөрийг үнэлж, гавьяат цолоор шагнажээ. Энэ шагналын утга учир нь юунд оршиж байна вэ?

-Би боловсролын салбарт 36 жил ажиллаж байна. Энэ хугацаанд ерөнхий боловсролын сургуульд математикийн багш, хичээлийн эрхлэгч, анги удирдсан багш, Ардын боловсролын хэлтэст байцаагч, Сурган хүмүүжүүлэх ухааны кабинетэд мэргэжилтэн, сургалт заах аргын кабинетэд мэргэжилтэн, эрхлэгч, Боловсрол төвийн захирал, Боловсрол, соёлын төвийн захирал, Боловсрол соёлын газрын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ажилласан юм.

Ер нь хөдөө орон нутгийн боловсролын байгууллага түүхэндээ зургаан удаа бүтцийн өөрчлөлт хийж, энэ бүхэнд үйл ажиллагааны чиг үүргээ өргөтгөж, удирдлагын бүтцийг сайжруулж ирсэн байдаг. Миний бие удирдлагын бүтцийн энэ зургаан том өөрчлөлтөөр (1991-2013 он) захирал, даргаар ажилласан их сонин намтартай. СХУК, Сургалт

заах аргын кабинет, САЗТөв, Боловсрол төв, Боловсрол Соёлын Төв, Боловсрол Соёлын Газрын даргаар 1991-2013 онд ажиллаж байлаа. 1991 онд ажил авахад манай аймагт олон мянган хүүхэд сургууль завсардчихсан, багш нарын хүрэлцээ хангамж муу, сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлгүй шахам болчихсон, дээр нь удирдлагын хуучин бүтэц тогтолцоог халчихсан, дэлгүүрүүдийн лангуу хоосорчихсон шилжилтийн хүнд үе байв. Ингээд бид удирдлагын шинэ багаа тэр үеийн Өвөрхангай аймгийн боловсролын хамгийн нэр хүндтэй, ур чадвартай, мэдлэг боловсрол, ажлын туршлага сайтай хүмүүсээр бүрдүүлэн ажиллаж билээ. Эргээд харахад, Өвөрхангай аймгийн Боловсрол соёлын салбарыг тасралтгүй 23 жил удирдан ажилласан байна. Өнөөдөр манай аймгийн Боловсрол, соёлын салбар улсын тэргүүний салбар болон үнэлэгдэж, багш нарынхаа хүрэлцээ, ур чадвар, боловсролын байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломж, сургалтын орчин, сургалтын чанар үр дүн гээд олон үзүүлэлтээрээ улсдаа тэргүүлж байх жишээтэй. Энэ хугацаанд надтай хамтран ажилласан үе үеийн аймаг орон нутгийн удирдлагууд, боловсрол, соёлын төв, газрын хамт олон, Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагууд, багш сурган хүмүүжүүлэгчид, шавь нартаа гүн талархал илэрхийлж, ажлын амжилт, амьдралын хамгийн сайн сайхан бүхийг хүсье.

ШИНЭ НОМ



“Тэнгэрийн хүүхдийн наадагтай”-г хэрхэн тайлсан бол?

Г.ГАНЧИМЭГ

Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч, орчуулагч, судлаач Го.Аким өчигдөр нэгэн шинэ бүтээлээ өлгийдөн авч номын садан нөхдөө цуглуулан хуримлав. Тэрбээр Монгол орны хадны зургуудад хийсэн судалгаа шинжилгээндээ суурилан “Тэнгэрээс заргагсдын “мөр”-ийг “Тэнгэрийн хүүхдийн наадагтай”-г бүтээж, номын нээлтээ Үндэсний номын санд хийсэн юм.

Соёлын гавьяат зүтгэлтэн, судлаач Го.Аким “Хадны зургууд маш сонирхолтой. Бидний өвөг дээдэс хадны зургийг “Тэнгэрийн хүүхдийн тоглоом”, “Тэнгэрийн хүүхдийн наадагтай” гэж нэрлэдэг байсан. Энэ нь хадны зургийг монголчууд ихээхэн дээдэлдэг байсны илрэл. Монголын нутагт байгаа хадны зургуудыг монгол хүн л түвэггүйхэн тайлж чадна. Түүнээс биш гадаадын хүн хараад ойлгохгүй шүү дээ” гэв.

Түүний үзэж буйгаар бол хүн төрөлхтөн Азид, Африкийн аль нэгэнд нь түрүүлж үүсээгүй. Нэгэн зэрэг Азид ч, Африкт ч, бас Америкт үүссэн гэнэ. Учир нь Африкт буй хадны зураг дээр африк хүнийг, Монголд буй хадны зурагт монгол хүн, монгол ахуй, заншлыг л дүрсэлсэн байдаг аж. Тиймээс гэхэд, сүүлийн нь боосон морь унасан баатрын зургийг үзээд гадаадын хүмүүс тайлж уншиж чадахгүй аж. Харин монгол хүн бол дайн тулааны үед морины дэлийг нүдэнд нь оруулахгүй, сүүлийн нь ямар нэгэн юманд тээгүүлж орооцолдуулахгүй хэмээн болзошгүй аюулаас сэргэмжилсэн байна гэдгийг түвэггүй тайлж чадна.

Үүнээс гадна маш сонирхолтой нэгэн мэдээлэл хадны зургуудаас олджээ. Тодруулбал, манай нутагт өөр гаригийнхан ирсэн байж болзошгүй гэнэ. Үүнийг юугаар нотлох вэ гэвэл говиос олдсон хадны зургуудад нисдэг таваг ч юм уу ямар нэгэн нисдэг биетийг дүрслэн үлдээсэн явдал юм. Энэ мэтийн сонирхолтой мэдээллийг хадны зургаар дамжуулж авья гэвэл уншигч авхай та “Тэнгэрийн хүүхдийн наадагтай”-г хэрхэн тайлсаныг энэхүү номоос уншаарай.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017.05.18
Тендер шалгаруулалтын нэр: Сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэх тухай дотоодын нээлттэй тендер шалгаруулалт
Тендер шалгаруулалтын дугаар: ХЭБ-2017/001-018

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2017 онд шинэчилж зохиосон ерөнхий боловсролын сургуулийн VI ангийн 1, VII дугаар ангийн 5, VIII ангийн 6, IX ангийн 5, X ангийн 11, XI ангийн 11, VI-VII ангийн 2, VIII-IX, X-XI дүгээр ангийн тус бүр 1 нэрийн болон гадаадад суугаа монгол иргэдийн хүүхдэд зориулсан I-V ангийн Монгол хэлний цахим сурах бичиг, багшийн ном тус бүр 1 нэрийн, хөгжлийн бэрхшээлтэй суралгчдын 4 нэрийн сурах бичиг тус бүрийн хэвлэлийн эхийг бэлтгэж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер шалгаруулалт нь 18 багц бүхий 1 тендер байна.

Багц	Багц дахь сурах бичгийн эхийн нэр	Тендерийн баталгаа /Төгрөгөөр/	
Багц 1	ХЭБ 2017/001	Дизайн технологи VI, Физик VII, Биологи VII	170,640.00
Багц 2	ХЭБ 2017/002	Нийгэм судлал VII, Дизайн технологи VII, Орос хэл VII (CD–тэй)	151,680.00
Багц 3	ХЭБ 2017/003	Монгол хэл VIII, Уран зохиол VIII, Үндэсний бичиг VIII	170,640.00
Багц 4	ХЭБ 2017/004	Газарзүй VIII, Нийгэм судлал VIII, Казах хэл, уран зохиол VIII	161,160.00
Багц 5	ХЭБ 2017/005	Монгол хэл IX, Уран зохиол IX, Үндэсний бичиг IX	170,640.00
Багц 6	ХЭБ 2017/006	Газарзүй IX, Нийгэм судлал IX, Монгол хэл X	132,720.00
Багц 7	ХЭБ 2017/007	Уран зохиол X, Математик X, Биологи X	170,640.00
Багц 8	ХЭБ 2017/008	Физик X, Хими X, Монголын түүх X	142,200.00
Багц 9	ХЭБ 2017/009	Нийгэм судлал X, Газарзүй X, Англи хэл X (CD–тэй)	199,080.00
Багц 10	ХЭБ 2017/010	Орос хэл X (CD–тэй), Монгол хэл XI, Уран зохиол XI	142,200.00
Багц 11	ХЭБ 2017/011	Математик XI, Монголын түүх XI, Газарзүй XI	170,640.00
Багц 12	ХЭБ 2017/012	Биологи XI, Физик XI, Хими XI	170,640.00
Багц 13	ХЭБ 2017/013	Англи хэл XI (CD–тэй), Орос хэл XI (CD–тэй), Бизнес судлал XI	199,080.00
Багц 14	ХЭБ 2017/014	Дүрслэх урлаг VI-VII, Хөгжим VI-VII (CD–тэй), Хөгжим VIII-IX (CD–тэй), Үндэсний бичиг X-XI	227,520.00
Багц 15	ХЭБ 2017/015	Математик IV /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралгчдын/, Монгол хэл V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралгчдын/	180,120.00
Багц 16	ХЭБ 2017/016	Монгол хэл V /Сонголын бэрхшээлтэй суралгчдын/, Дүрслэх урлаг, технологийн I-V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй суралгчдын/	199,080.00
Багц 17	ХЭБ 2017/017	Монгол хэл I-V /Цахим сурах бичиг/	284,925.05
Багц 18	ХЭБ 2017/018	Монгол хэл I-V /Цахим сурах бичгийн багшийн гарын авлага/	178,078.15

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлийг нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Төрийн сан 100900015003 тоот дансанд шилжүүлнэ.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Сүүлийн 2 (2015, 2016 он) жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерийн тухайн багцад санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 60%-тай тэнцүү ба түүнээс дээш хэмжээтэй байна.
- Сүүлийн 2 (2015, 2016 он) жилийн санхүүгийн аудитлагдсан тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 (2015, 2016 он) жилийн хугацаанд энэхүү тендер шалгаруулалтаар гүйцэтгэх ажилтай адил хамгийн багадаа 1 гэрээг гүйцэтгэсэн байх бөгөөд түүний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 60 хувинс багагүй байна.

Тендерийн баримт бичгийг худалдан авахдаа хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.

Тендерийн хамт дээрх хүснэгтэд багц тус бүрээр заасан дүнтэй тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийг 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшуулан тендерийг 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 10.10 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцоггүй. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр, 4 дүгээр давхар, 420 тоот өрөө
Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн Ч.Ганцэдэг
Утас 263284, Факс: 976-11-323589

ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ЗОЧИН



М.СЭРГЭЛЭН: МОНГОЛ-ЯПОНЫ САНСРЫН ХАМТАРСАН СУДАЛГАА, ТУРШИЛТЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХИЙНЭ

Ц.УНДАРМАА

"Техник Технологийн Дээд сургууль" болон тус сургуулийн харьяа "Монгол Коосэн" сургуулийн Японы эрдэмтэдтэй хамтран хийж буй сонирхолтой туршилтыг уншигч та бүхэндээ толилуулахаар ТТДС-ийн ерөнхийлөгч М.Сэргэлэнтэй цөөн хором ярилцлаа.

Чибягийн Технологийн Дээд сургуультай хамтран хийж байгаа судалгааны талаар дэлгэрэнгүй ярихгүй юу. Тун сонирхолтой судалгаа хийгдэж байгаа гэх юм?

Амьдрал хаана үүссэн бэ. Дэлхий дээр үүсэв үү, эсвэл сансар огторгуйгаас хийсэн ирээ үү гэдэг нь нэн сонирхолтой асуулт. Дэлхийн олон эрдэмтэн судлаачид энэ талаар судлаж байгаагийн дотор Японы эрдэмтэн, Чибягийн Технологийн Дээд сургуулийн ТУЗ-ийн дэд дарга Мацүи Такафүми профессор судлаж байгаа юм. Мацүи профессор Чибягийн Технологийн Дээд сургууль дээрээ Гараг ертөнцийг судлах судалгааны төвбайгуулан (PERC), тэрхүү төвөөрөө дамжуулан манай Техник Технологийн Дээд сургуультай хамтран агаарын бөмбөлөг хөөргөж, агаар мандал дахь тоосонцрыг тусгай мэдрэгч багажаар хэмжих туршилт, судалгааны ажлыг 2016 онд эхлүүдсэн. Дэлхийн агаар мандлаас 40 км-ийн өндөрт агаарын бөмбөлөг ашиглан тоосонцор цуглуулах төхөөрөмжийг гаргах, цуглуулсан тоосонцор дотор магадгүй ямар нэгэн амьд биет, бактери, микроб байх аваас үүний гарал үүслийг судлах зорилготой юм. Хэрвээ тэрхүү амьд биет нь дэлхийн гаралтай биш байна гэдэг нь нотлогдож чадвал Коперникийн нээлттэй эн тэнцэхүйц нээлт болно гэж судалгааны хамтарсан баг үзэж байгаа.

Хамтарсан судалгааг яагаад Монголд хийх болсон бэ?

Энэхүү туршилтыг Монголд хийж байгаа нь манай орны өргөн уудам газар нутагтай холбоотой гэж хэлж болно. Учир нь Японд агаарын бөмбөлөг хөөргөсөн төхөөрөмжөө буулгахдаа заавал далайн мандалд буулгах хуультай байдаг юм байна. Агаарын бөмбөлөг хөөргөсөн цэгээсээ 60-70 км-ийн радиуст бууж ирдэг тул манай улс шиг өргөн уудам газар энэ талын туршилтыг явуулахад таатай гэж хэлж болно. Орон орны эрдэмтэн мэргэд өөрийн онцлог, өвөрмөц талаа уялдуулж чадваас шинжлэх ухааны нээлт ололт хийхэд дөхөм байх боломжтой юм байна гэж бодогдож байгаа.

Эхний туршилт хэзээ, хаана хийгдсэн бэ?

Агаарын бөмбөлөг хөөргөх эхний туршилтыг 2016 оны зургадугаар сард Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын ойролцоох газар хийсэн. Төхөөрөмжийг 40 км өндөрт гаргаж чадсан. Агаарын бөмбөлөг стратосферын давхаргад гарахад агаарын даралт бага байх тул томорч тэлнэ. Газар дээрээс хөөргөх үед агаарын бөмбөлгийн диаметр 2 м гаруй байх боловч 30-40 км-ийн өндөрт гарах үед дотроосоо гелий шахсан бөмбөлөг гаднаа агаарын даралт багасах тул тэлж томрон, хана нь нимгэрсээр 20 м гаруй диаметртэй болоод хагардаг байгаа юм. Бөмбөлөг хагармагц шүхэр дэлгэгдэж, төхөөрөмж аажмаар буух бөгөөд замдаа сансрын тоосонцор цуглуулж ирнэ гэж тооцсон. Эхний туршилтын үеэр хөгтэй зүйл хэд хэд гарсан шүү. Агаарын бөмбөлөгтэй төхөөрөмж маань 40 км-ийн өндөрт амжилттай гэрч чадсан боловч төхөөрөмж газардсаны дараа хайх машин шаварт суугаад цаг нэлээн алдсан. Нэлээдгүй мунгинасны эцэст газардсан цэг дээр яваад очтол ойролцоо айлын 10 настай хүүхэд төхөөрөмжийг олоод хамаг зүйлийг нь задалчихсан, битүүмжийг нь алдагдуулчихсан байсан. Зургийн апаратыг нь авчихаад өгөхгүй гэж гүрийгээд, нэлээд дипломат хэлцэл хийсний үр дүнд буцааж авч байлаа. Шүхэр нь тод ягаан өнгөтэй тул алсаас их тод харагддаг. Нөгөө Монгол хүүхэд бол их сонинч, элдэв техник задлах авьяастай гэдэг нь харагдаад байгаа юм.

Мэдээж анхны зүйлд алдаа мадаг гаралгүй яахав. Дараа дараагийн туршилтад мэдээж туршилагажсан байх?

Тэгсэн. Үүний дараа өнгөрөгч оны есдүгээр сарын 19-20-ны өдөр хоёр удаа Тэрэлжийн "Цэвэгмаа" амралтын газраас 23, 33 км өндөрт агаарын бөмбөлөг тус тус хөөргөж урьдчилан тооцоолсон цэг орчимд амжилттай буулгасан. Хоёр дахь өдрийн туршилтыг Японы телевизийн захиалгаар хөөргөсөн юм. Агаарын бөмбөлөгт шар айраг, загас, өндөг зэрэг хүнсний бүтээгдэхүүн дайж явуулаад буугаад ирэхэд амт нь хэрхэн өөрчлөгдөх вэ гэдэг сонирхолтой туршилт хийсэн. Энэ тухай Японы телевизээр өнгөрөгч оны арваннэгдүгээр сард "Токоро санно мэгатэн" гэдэг нэвтрүүлгээр гарсныг манай монголын үзэгчид олж үзсэн байх. Туршилтыг Японы Чибягийн Технологийн Дээд сургуулийн Гараг ертөнцийг

судлах судалгааны төв (PERC), Мацүи профессорын үүсгэн байгуулсан ИСПА (ISPA) ТББ, Вакаяма их сургууль, ЯманашИх сургууль, Монголын Техник Технологийн Дээд сургууль, Монгол Коосэн Технологийн коллеж, ШУТИС, ШУТИС-ийн Коосэн загварын Технологийн Дээд сургуулийн багш, оюутнууд хамтран явуулсан. Сансрын тоосонцор цуглуулах төхөөрөмжөөс гадна маш олон төрлийн зургийн камер, агаарын дулаан, даралт хэмжих сенсор, GPS болон холбооны төхөөрөмжийн найдвартай ажиллагааг шалгах туршилт мөн давхар явагддаг. Зорчигч тээврийн онгоц 10-11 км-ийн өндөрт нисдэг, түүнээс дөрвө дахин өндөрт гаргахад төхөөрөмж эвдрэх, буруу ажиллах зэргээр бага сага алдаа бас гардаг. Алдаан дээрээ дүгнэлт хийгээд дараагийн удаа яах вэ, ямар арга хэмжээ авах вэ зэргээр бодож тунгаах нь танхимын хичээлээс илүү оюутанд илүү өгөөжтэй, бодит мэдлэгтэй болох ач тустай юм. Мөн манай оюутнууд энэхүү туршилтаар дамжуулан мэдлэгийн хүрээгээ тэлээд авах боломжтой юм. 11 км-ийн өндөрт агаарын температур Цельсийн -50 градус байдаг бол 40 км-т Цельсийн +7 градус байдгийг энэ туршилтын үеэр бодитоор хэмжээд ирэх жишээтэй.

ИСПА (ISPA) байгууллагын тэтгэлгийн талаар тодруулвал?

Мацүи профессорын үүсгэн байгуулсан ИСПА (ISPA) төрийн бус байгууллагаас жил бүр олгохоор шийдвэрлэсэн "ИСПА тэтгэлэг" хөтөлбөрт ТТДС-ийн харьяа "Монгол Коосэн" сургуулийн таван оюутан шалгарсан байгаа. Тодруулбал, Цахилгааны инженерийн хоёрдугаар курсийн оюутан Э.Бат-Эрдэнэ, Барилгын инженерийн хоёрдугаар курсийн оюутан Б.Ариунсайхан, Био инженерийн хоёрдугаар курсийн оюутан А.Жаргалмаа, Барилгын инженерийн хоёрдугаар курсийн оюутан Б.Мөнхчимэг, Механикийн инженерийн гуравдугаар курсийн оюутан Н.Мөнгөн-Очир нар тус тус шалгарлаа. Шалгарсан таван оюутанд 100.000 иен буюу 2.2 сая төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгохоор болсон. Цаашид "ИСПА" энэ тэтгэлгээ жил бүр олгож, ирээдүйд амжилт гарган, Монголынхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулаасай хэмээн урам өгч, оюутны сурч мэдэх, судлаж туршихыг нь хөхүүлэн дэмжих зорилготой юм.

Агаарын бөмбөлөг хөөргөх судалгааны дараагийн туршилтын хэзээ явагдах бол?

Ирэх зургадугаар сард дараагийн туршилтаа хийхээр одооноос бэлтгэж байна. Агаарын бөмбөлөг ашиглан олон төрлийн судалгаа хийх боломжтой байдаг. Сансар огторгуйн судалгааг ч мөн адил агаарын бөмбөлөг хийх нь пуужин, хиймэл дагуул хөөргөхөөс үнэ өртөг багатай, оюутан сурагчид ч хийх боломжтой байдгаараа давуу талтай. Монгол хүний сэтгэлгээ, ур ухааныг дэвшилтэт технологитой уялдуулан, техникийн дэвшил, технологийн өндөр хөгжилтэй орны туршилагаас суралцах чадвартай монгол сэтгэлгээтэй, бүтээгч инженер бэлтгэх нь бидний эн тэргүүний зорилт билээ.

...Тус сургуулийн Ерөнхийлөгчтэй бид ярилцсаны дараа Мацүи профессорын үүсгэн байгуулсан ИСПА (ISPA) төрийн бус байгууллагаас жил бүр олгохоор шийдвэрлэсэн "ИСПА тэтгэлэг" хөтөлбөрт шалгарсан Био инженерийн хоёрдугаар курсийн оюутан А.Жаргалмаагийн сэтгэгдлийг сонслоо.



Био инженерийн 2-р курсийн оюутан А.Жаргалмаа :

Энэ хичээлийн жилд Сансар судлалын ИСПА байгууллагаас тэтгэлэг хүртсэн. Энэхүү тэтгэлгийн эхний шалгуур хүүхдүүдийн сурлага мэдлэг, амжилт, идэвх зэргийг харгалзан үзэж 12 хүүхдийг сонгон дараагийн шатны ярилцлагад оруулсан юм. Ярилцлагаас таван хүүхдийг шалгаруулж тэтгэлэг гардуулсны нэг нь би байсан юм. Миний хувьд "Монгол Коосэн" сургуульд орж ирсэн цагаас хичээл сурлагадаа шамдах болж бүтээх ухааны олон талын чадварт суралцаж түүгээрээ ч бишгүй амжилт гаргасанхаа дунд энэхүү тэтгэлэгт хамрагдсан гэж бодож байна. Мөн тодорхойлсон зорилго, цаашдын зорилт мөрөөдлөө биелүүлэхэд хамгийн том урам итгэлийг энэ тэтгэлэг надад өгсөн.



Агаарын бөмбөлөгийн шүхэрт гарын үсэг зурж дурсгал болгон үлдээв



Гелигээр дүүргэсэн бөмбөлөг хөөргөх гэж байгаа нь 2016.9.сар



ISPA (<http://www.ispajapan.com/>) Сансар судлалын хүрээлэнгийн тэтгэлэгт хөтөлбөрт манай сургуулийн таван оюутан хамрагдаж 100.000 иенийн тэтгэлэг хүртлээ. Энэхүү тэтгэлгийг цаашид жил бүр уламжлал болгон олгох юм.



Зүүн гар талаас ИСПА (ISPA) ТББ байгууллагаас тэтгэлэг авсан оюутан Н.Мөнгөн-Очир, Б.Ариунсайхан, Б.Мөнхчимэг, А.Жаргалмаа, Э. Бат-Эрдэнэ

ЦАЙНЫ ТӨГС ХОСЛОЛ

GreenCity
Албан ёсны дистрибьютор